

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам), Баярням Хонгорзул

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, нийгмийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах;							
1	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулна.	Боловсруулах бодлогын баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг батлуулсан.	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /Нийт 6 бодлогын баримт бичиг/	6 Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулах ажлын хүрээнд Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					төслүүдийг боловсруулж байна.		
2	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" -ийг батлуулсан.	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /1 төлөвлөлтийн баримт бичиг/	Хугацаа болоогүй.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г батлуулсан.	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /1 төлөвлөлтийн баримт бичиг/	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлуулсан. Төлөвлөгөөнд "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдийн засгийн эрх чөлөөний реформын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, татварын орчны шинэчлэлийг хийж, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулалтыг		
--	--	--	--	--	--	--	--

					хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасгах, ялгамжтай байдлыг арилгана. Төсвийн зардлын реформын хүрээнд төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, процессын дахин инженерчлэлийг хийж, төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй, про-актив хандлагаар эрчимжүүлнэ. Төрийн албаны реформын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ. Үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформын хүрээнд төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, бүтээмжийг сайжруулж, зардлыг бууруулж, тэдгээрийн хөрөнгийн удирдлагыг		
--	--	--	--	--	---	--	--

					сайжруулна. Баялгийн санг арвижуулах, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц арга хэмжээг хэрэгжүүлж, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчимд суурилсан, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй бүрэн уялдсан.		
--	--	--	--	--	---	--	--

1.2. Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;

4	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.	Арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх, хувиар	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж, улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	---	---	---	--	---	------

					ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г батлуулсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ"-ыг зорих бөгөөд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.		
5	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар судалж, боловсруулна.	-	Өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулсан байна. /100 хувь/	Өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулсан байна. /100 хувь/	Монгол улсын дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					батлуулан, Үнэлгээний хороог байгуулсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулийн дагуу худалдан авах зөвлөх үйлчилгээг зарлаад байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.1.5-д “Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлого нь нотолгоонд суурилсан байх тогтолцоог бүрдүүлж, батлан гаргаж байгаа нийт бодлогын 70 хувиас доошгүйг судалгаанд суурилж боловсруулна.” гэж заасан. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн, салбар болон салбар хоорондын уялдааг		
--	--	--	--	--	---	--	--

					хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтүүдийн талаар нарийвчилсан тооцоо, судалгаа хийх зайлшгүй шаардлага бий болсон. Дээрх цогц судалгааны ажлын хүрээнд: -Монгол улсын дунд хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийхийн тулд олон төрлийн өгөгдлүүд, загвар ашиглах; -Уялдаа холбоотой системүүдийн хөгжлийг загварчлах, орон нутаг болон салбар хоорондын харилцан үйлчлэлийг харах зорилгоор Системийн динамик (System Dynamics) загвар ашиглах; - Орон нутаг, салбар хоорондын өөрчлөлтүүдийн		
--	--	--	--	--	--	--	--

					нөлөөг тооцоолох Динамик симуляц ашиглах зэрэг хөгжлийн загваруудыг хөгжүүлнэ.		
6	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж эхэлсэн байна. /100 хувь/	Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулахаар шийдвэрлэсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт " Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө." гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					сан байгуулах Ажлын хэсгийг байгуулж байна. Тус Ажлын хэсэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан, Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах үйл явцыг удирдан зохион байгуулах, холбогдох байгууллагуудын мэдээллийн урсгалын нэгтгэл, харилцан уялдааг сайжруулах, мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх үүрэгтэй болно.		
7	Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар	Монгол Улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх, хувиар	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа	-	Хугацаа болоогүй.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	зөвшөөрөл өгнө.		эсэх асуудлаар 2024 онд зөвшөөрөл өгсөн.				
8	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байх, хувиар	Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр зохион байгуулсан.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг тасралтгүй хэрэгжүүлж байна. Тухайлбал, Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог (багш, эмч нараас бусад) 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийв. Мөн Монгол Улсын хэмжээнд цогц үйлчилгээний төвүүдийг байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийлээ. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд: - "Олон хэвт эдийн засаг, суртахууны эдийн засаг" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр яамны албан хаагчдад зохион байгуулав.		
1.3. Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;							
9	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх, хувиар	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна. /100 хувь/	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Төлөвлөгөөнд “Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох”-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд ядуурал, тэгш бус		
--	--	--	--	--	---	--	--

					байдлыг бууруулж, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлаж, боловсролын чанар, хүртээмж дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг өсгөж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, “Хамгийн сайн цэцэрлэг, сургууль-гэрт ойр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгана. Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн ур чадварт сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах бодлого баримталж, мэдээлэл, харилцаа, технологийн ололтод суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл		
--	--	--	--	--	--	--	--

					мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх төвд нийгмийн үйлчилгээг нэвтрүүлж, өргөжүүлнэ. Нийгмийн баталгааг хангаж, Чингис хаан Үндэсний баялгийн сангаар дамжуулан ирээдүйд хөрөнгө оруулалт хийх эрүүл мэнд, боловсрол, орон сууцруулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Миний амины орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлс, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр гэж тус тус бодлогыг тодорхойлж тусгасан.		
10	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага,	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р	100%

	тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангана.	зохион байгуулалтаар хангасан байх, хувиар		байгуулалтаар хангасан байна. /100 хувь/	хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлуулсан. Төлөвлөгөөнд "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	---	--	---	---	---	--

					боловсронгуй болгож, ЭМД-ын сангаас санхүүжиж буй тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ" Хүн төвтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймгуудад байгуулж, зорилтот өрх, хүнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлнэ" гэж хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтөд тусгасан.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

					330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд ядуурал, тэгш бус байдлыг бууруулж, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлаж, боловсролын чанар, хүртээмж дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг өсгөж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, “Хамгийн сайн цэцэрлэг, сургууль-гэрт ойр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгана. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлж, хавдар, зүрх судасны өвчлөлийн эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлж, эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хиймэл оюун ашиглан		
--	--	--	--	--	--	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны мэргэшүүлэх дунд, богино хугацааны сургалтад хамрагдах	Удирдлагын академаас зохион байгуулах сургалтад хамрагдаж, мэргэшил чадвараа сайжруулна. ур	-	1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр нийт 5 уулзалт, хэлэлцүүлэг, семинарт оролцсон. Үүнд Хөдөлмөрийн бүтээмжийн талаар хэлэлцүүлэгт пиналистаар, 2025 оны 05 дугаар сарын 22-нд НҮБ -ын Суурин зохицуулагчийн газар Засгийн газартай хамтран зохион байгуулсан ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2025"-ИЙГ ТАНИЛЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ болон Хиймэл оюуны эрин дэх хүмүүсийн сонголт ба боломжууд хэлэлцүүлэгт пинастаар оролцсон. Мөн Алсын хараа -2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын тайланг боловсруулах дэд ажлын хэсгийн тайлангийн хэлэлцүүлэгт оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Мэргэжлийн чиглэлээр докторын сургалтад хамрагдах	МУИС-д Антропологийн чиглэлээр докторын сургалтад хамрагдана.	1 жил суралцсан	Үргэлжлүүлэн суралцана	Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн Антропологи, археологийн тэнхимын докторын хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд элсэж 2-р улиралд Улс төрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	100%

					либерализм хичээлийг нийт 16 цагийг судалж дүгнүүлсэн. Мөн Хөгжлийн антропологи хичээлийн семинарыг докторын хөтөлбөрт хамрагдаж буй судлаач оюутны хувьд бакалаврын оюутнуудад нийт 16 цаг заасан.	12-р сар	
--	--	--	--	--	---	----------	--

ХЯНАСАН:

Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга Л.Балчинлувсан

/...../

Огноо:

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам), Баярням Хонгорзул

/...../

Огноо: 2025.06.25

